



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

┌ Зочид буудал, дэн буудал, амралтын ┐
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1 дэх хэсэг, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Итгэлт түнш ХХК-ийн “Ланд” зочид буудлын 19/376, Авдар өргөө ХХК-ийн “Жэй” зочид буудлын 19/304, Урсгал Хайрхан гол ХХК-ийн “Урсгал Хайрхан гол” дэн буудлын 20/333, Монгол Цзэн Тай ХХК-ийн “Вен Жөү” зочид буудлын 19/319, Батбадруун ХХК-ийн “Бадруун” дэн буудлын

1150500241

19/343, Гоо Бугат ХХК-ийн "Чили" дэн буудлын 19/348, Хос Бэрс ХХК-ийн "Бэрс" дэн буудлын 19/265, Огторгуйн Цаг ХХК-ийн "Хас" дэн буудлын 19/236, Дөл Тулгуур ХХК-ийн "Таван Од" дэн буудлын 19/301, Уянга-Уул ХХК-ийн "Уянга" дэн буудлын 19/373, Манкур ХХК-ийн "Манкур" дэн буудлын 19/364, Цацал Мон ХХК-ийн "Цацал Мон" дэн буудлын 19/347, Мөнгөн Ундраа ХХК-ийн "Би Жи" дэн буудлын 19/368 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА  С.БАТБААТАР

5284025 СБТ 8926 1118263502

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 10 сарын
05-ны өдрийн А/77 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-2926 1118263502

**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Драгон финанс ХХК	5809037	Хотел Драгон	СХД-ийн 29-р хороо, Москвагийн гудамж, 4-р хороолол 71
2	Итгэлт түнш ХХК	2791293	Ланд	БГД-ийн 16-р хороо, Амарсанаагийн гудамж 54
3	Авдар өргөө ХХК	5234476	Жэй	СБД-ийн 1-р хороо, Автозамчдын гудамж 34
4	Урсгал хайрхан гол ХХК	6534538	Урсгал Хайрхан Гол	БГД-ийн 9-р хороо, Хасбаатарын гудамж 23-5
5	Монгол Цэн тай ХХК	2668289	Вен Жөү	БЗД-ийн 14-р хороо, Намьяанжүгийн гудамж 19

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 10 сарын
05-ны өдрийн А/77 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ-8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мудагуга ХХК	5832012	Лила	БЗД-ийн 4-р хороо, Доржийн гудамж 48/3 тоот
2	Батбадруун ХХК	5026776	Бадруун	СБД-ийн 13-р хороо, Рашааны 8-504
3	Гоо бугат ХХК	6035795	Чили	СБД-ийн 10-р хороо, Цагдаа 39
4	Хос бэрс ХХК	5009995	Бэрс	БГД-ийн 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Эх гудамж 41/3 тоот
5	Огторгуйн цаг ХХК	5064635	Хас	БГД-ийн 20-р хороо, Товчооны зам 25-2
6	Дөл тулгуур ХХК	5574293	Баялаг	СХД-ийн 6-р хороо, Ханын материалын эцэс
7	Эйч эйч ар ХХК	6550622	Уянга	СБД-ийн 10-р хороо, 82-2
8	Манкур ХХК	2881039	Манкур	БГД-ийн 16-р хороо, Туулын 19-386
9	Цацалмон ХХК	2085801	Цацалмон	БГД-ийн 20-р хороо, Москвагийн гудамж 35 тоот
10	Мөнгөн ундраа ХХК	6014054	Би Жи	СХД-ийн 5-р хороо, 41-н 16

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 10 сарын
05-ны өдрийн А/77 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Цагаан хулан ХХК	5247527	Сайн	НД-ийн 6-р хороо, Горхи Тэрэлжийн Хөмөг
2	РЭАБ ХХК	5496802	Жи Дилюкс	БЗД-ийн 20-р хороо, Даваатын ам
3	Алаг дөл ХХК	5690773	Мойлтын хүрээ	НД-ийн 1-р хороо, Мойлтын тохой

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР